



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/237


Есөнбулаг

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/214 дугаартай "Өвсний үндэс" хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдэх "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийн 1 дүгээр заалтад "Үнэлгээний хорооны дарга: Г.Болдбаатар -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч" гэснийг "Үнэлгээний хорооны дарга: Ш.Насан -аймгийн Жангар музейн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч" гэж өөрчилсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журамд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороо (Ш.Насан)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ